



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 1/779

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 2020 онд хэрэглэгдэх эм эмнэлгийн хэрэгсэл, орох боох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга
Нарийн бичгийн дарга: Т.Эрдэнэсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Р.Наранцэцэг -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Дашжанцан -Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн стратеги төлөвлөлт хариуцсан дэд захирал

Д.Мөнхнасан -Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал

Ш.Авиurmэд -Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцсэнөөр)

Т.Нарангарав -аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101457

D:My Doc. Zahiramj. Zasag darga